



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД МАРГААН ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН
ЗАРДЛЫН ТООЦОО**

2023

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, хууль зүйн ухааны доктор (Dr.jur)
----------------	--

Судалгааны багийн гишүүд:

М.Түвшинжаргал	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн ухааны доктор (Ph.D)
Б.Энх-Амгалан	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хууль зүйн ухааны магистр (LL.M)
Д.Дэмидханд	Эрдэм шинжилгээний ажилтан
С.Нарантунгалаг	Эрдэм шинжилгээний ажилтан

АГУУЛГА

I. УДИРТГАЛ	4
II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО	5
2.1. Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох	23
2.2. Хүний нөөцийг тодорхойлох	25
2.3. Гарах зардлыг урьдчилан тооцох	33
2.4. Үр дүнг тооцох	34
2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах	37
IV ДҮГНЭЛТ, САНАЛ	38

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

I. УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж өргөн мэдүүлэхээр тусгасны дагуу Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд Цэц нь иргэнээс ирүүлсэн “үндсэн эрх” зөрчигдсөн талаарх өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх, иргэн Цэцэд хандахын өмнө эрх сэргээх, хамгаалах шүүхийн болон бусад арга замыг гүйцээсэн байх, иргэнээс Хүний эрхийн Үндэсний Комисст гаргасан асуудал иргэний үндсэн эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй бол түүнийг тогтоолгохоор Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Цэцэд мэдээлэл гаргах, иргэн Үндсэн хуулийн холбогдох заалт зөрчигдсөн талаар тухайн чиглэлийн төрийн бус байгууллагад нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хандсан нь үндэслэлтэй бол тухайн байгууллага Цэцэд мэдээлэл гаргах, Цэцэд хандаж буй эрх зүйн акт, маргааны төрлөөс хамаарч тухайлан хугацаа тогтоох, Цэцэд ирсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг илтгэгч гишүүнд хуваарилах болон Цэцийн хуралдааны бүрэлдэхүүнийг томилохдоо Цэцийн гишүүдийн зөвлөгөөнөөр тухайн жилд тогтоосон хуваарь, журмыг баримтлах, Үндсэн хууль зөрчсөн тухай Цэцийн шийдвэр гарснаар нийгмийн харилцаа зохицуулалтгүй орхигдохоор байвал Цэц шийдвэртээ хугацаа зааж, эрх бүхий этгээдэд шинээр зохицуулах ажиллагааг нэн даруй гүйцэтгэхийг даалгах, зохицуулалт хийгээгүйн улмаас бусдад учирсан хохирлыг тухайн байгууллага, албан тушаалтан хариуцах зэрэг шинэлэг зохицуулалтуудыг тусгасан байна.

Тодруулбал, уг төслөөр Үндсэн хууль, түүнчлэн хүний үндсэн эрхийг дээдлэн хамгаалах чиг үүрэгт нь нийцүүлэн Цэцийн үйл ажиллагааг улам боловсронгуй болгох зорилгоор Цэцэд хандах эрх бүхий этгээдийн хүрээ, тэдгээрээс Үндсэн хуулийн цэцэд хандах хамаарлын зарчмыг тодорхой болгох, иргэний үндсэн эрхийн баталгааг улам сайжруулах, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат, журмыг нарийвчлан зохицуулахыг зорьжээ.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, хялбарчлах болон бууруулах боломжит хувилбар бүхий санал боловсруулах, зардал, үр өгөөжийн харьцааг үнэлэхэд энэхүү судалгааны зорилго чиглэгдэнэ.

Ингэхдээ гагцхүү нэмэлтээр орсон эсхүл өөрчлөгдсөн чиг үүрэгтэй холбоотой зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцоолов. Өөрөөр хэлбэл, өөрчлөгдөөгүй буюу өмнө нь байсан чиг үүрэгтэй холбогдох аливаа зардлыг тус судалгааны хүрээнд тооцоогүй болно.

Судалгааны үр дүнд үндэслэн, тус хуулийн төсөл батлагдсанаар үүсэх зардлыг тооцон, зардал ба үр өгөөжийн харьцааг дүгнэж тайлан боловсруулав.

II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцно. Уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

- Байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
- Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
- Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Байгууллагын бүтэц бүрэлдэхүүн, зардал, ажлын ачаалалд нөлөө үзүүлэх боломжтой зохицуулалтыг сонгож авахдаа дараах чиг үүргийг “одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд тусгагдсан” гэсэн үндэслэлээр энэхүү зардлын тооцоонд оруулаагүй болно. Үүнд:

- 4.1.Цэц гагцхүү Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх бөгөөд бусад хууль зөрчсөн тухай өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авахгүй.
- 8.1.Цэцийн гишүүн аливаа байгууллага, албан тушаалтан, иргэнээс хараат бус байж, гагцхүү Үндсэн хуульд захирагдан маргааныг хянан шийдвэрлэнэ.
- 8.2.Байгууллага, албан тушаалтан, иргэн, хэн боловч Цэцийн гишүүн маргаан хянан шийдвэрлэх бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шахалт, дарамт үзүүлэх, бусад хэлбэрээр нөлөөлөхийг хориглоно.
- 8.3.Цэцийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ тал үл харах бөгөөд Цэцэд хянан шийдвэрлэж байгаа маргаан эсхүл ойрын ирээдүйд Цэцийн шийдвэрлэвэл зохих

- асуудлын талаар саналаа нийтэд урьдчилан илэрхийлэх, зөвлөгөө өгөхийг хориглоно.
- 9.1.Цэц нь аливаа асуудал, маргааныг хамтын зарчмаар хэлэлцэж, хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.
 - 10.1. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Цэц маргааныг ил тодоор хянан шийдвэрлэж, шийдвэрээ нийтэд мэдээлнэ.
 - 13.1. Цэц маргааныг монгол хэлээр хянан шийдвэрлэж, төрийн албан ёсны бичгээр хөтөлж баталгаажуулна.
 - 14.1.Цэцийн хуралдааныг хуулиар тогтоосон журмын дагуу томилсон бүрэлдэхүүн эхнээс нь дуусах хүртэл биечлэн явуулна.
 - 15.1.Цэцийн хуралдааныг амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна.
 - 15.2. Хуралдаанаар маргааныг хянан шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн бол бүрэлдэхүүн уг нөхцөл байдал арилах хүртэл боломжит хугацаагаар хуралдааныг хойшлуулна.
 - 36.1.Аман хуралдааны явцыг нэг бүрчлэн бичиж тэмдэглэнэ.
 - 36.2.Аман хуралдааны тэмдэглэлд дараах зүйлийг тусгах бөгөөд мэдээллийн технологийн хэрэгсэл ашиглаж болно:
 - 36.2.1.тэмдэглэлийн нэр, хуралдаан болсон огноо, газар, байр, хуралдаан эхэлсэн, дууссан цаг, минут;
 - 36.2.2.хуралдаан даргалагч, хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүд, нарийн бичгийн даргын нэр;
 - 36.2.3.хэлэлцэх маргааны агуулга;
 - 36.2.4.маргааны оролцогчийн нэр, ажил, албан тушаал,холбогдох бусад мэдээлэл;
 - 36.2.5.маргааны оролцогч, түүний төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан шаардлага, тайлбар, түүний хариу болон бусад тайлбар, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, тэдгээрийн санал, хүсэлт, асуулт, хариулт болон хуралдааны бусад явц бүрэн хэмжээгээр;
 - 36.2.6.хуралдааны явцад гарсан асуудлыг шийдвэрлэсэн аман магадлал, түүнчлэн шийдвэрийн агуулга;
 - 41.1.Бага суудлын бүрэлдэхүүн доор дурдсан үндэслэл байвал маргаан үүсгэхээс татгалзаж магадлал гаргана:
 - 41.1.1.Цэцийн харьяалан шийдвэрлэх асуудал биш;
 - 41.1.2.өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргах эрх бүхий этгээд биш, эсхүл түүнийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд гаргасан;
 - 41.1.4.өргөдөл, мэдээлэл, хүсэлт нь энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй;
 - 41.1.7.Цэцийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа;

- 43.1.Илтгэгч гишүүн маргааныг хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангаж, шаардлагатай бол дараах ажиллагааг явуулна:
 - 43.1.2.гэрчээр дуудах;
 - 43.1.3.шинжээч томилон дүгнэлт гаргуулах;
- 44.1.Цэцийн аман хуралдааныг Монгол Улсын төрийн сүлд, далбааг байрлуулсан, хэлэлцүүлэг хийх шаардлага хангасан танхимд явуулна.
- 44.3.Даргалагч хуралдааныг нээх бөгөөд оролцогчдын ирцийн талаар хуралдааны нарийн бичгийн даргаас тодруулж, хэлэлцэх маргааны агуулгыг зарлан мэдэгдэнэ.
- 44.4.Даргалагч маргааны оролцогчдоос эрх, үүрэгтэй танилцсан
- эсэхийг тодруулж, хүлээх хариуцлагыг тайлбарлана.
- 44.5.Даргалагч тухайн хуралдааны бүрэлдэхүүнийг зарлан, бусад оролцогчийг танилцуулж, тэдгээрийг татгалзан гаргах эрхтэй болохыг үндсэн оролцогч нарт тайлбарлана.
- 44.6.Даргалагч хуралдааны танхимд баримтлах журмыг танилцуулж, хуралдааны дэгийг сахих, даргалагчид захирагдах үүрэгтэйг маргааны оролцогчид болон танхимд байгаа бусад хүнд сануулна.
- 45.4.Гэрч, шинжээч хүрэлцэн ирээгүй тохиолдолд хуралдааныг үргэлжлүүлэх эсэхийг хуралдааны бүрэлдэхүүн хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 47.3.Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор, эсхүл Улсын Их Хурлын чуулганы чөлөөт цагт дүгнэлт гарсан бол Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор хуульд заасан журмын дагуу хэлэлцэж, тогтоол гаргана.
- 47.4.Онц болон дайны байдал зарласан, цэрэг хөдөлгөх шийдвэртэй холбогдсон асуудлаар гаргасан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хойшлуулшгүй хэлэлцэх бөгөөд үүнд энэ зүйлийн 47.3-т заасан хугацаа хамаарахгүй.

Аргачлалын 4.4.6-д заасны дагуу төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээ буюу дараах дүрэм, журам, стандарт, кодчиллыг батлах чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох зардлыг тус тооцоонд тусгаагүй. Үүнд:

- 5.1.Цэц энэ хуульд өөрөөр заагаагүй бол маргааныг үүсгэснээс хойш 90 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Хуралдааны бүрэлдэхүүн нь тухайн маргаан ээдрээ, төвөгтэй бол энэ хугацааг 90 хоногоор хоёр хүртэл удаа сунгаж болно. Холбогдох журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.
- 14.2.Хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар үргэлжлүүлэн ажиллах боломжгүй бол түүний оронд Цэцийн өөр гишүүнийг томилж, хуралдааныг эхнээс нь явуулах бөгөөд холбогдох журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.

- 13.3.Цэцийн хуралдаанд энэ хуулийн 13.2-т заасан этгээдээс гаргасан тайлбар, баримтыг тухайн бүрэлдэхүүн болон маргааны бусад оролцогчид, түүнчлэн тухайн этгээдэд хуралдааны явц, бусад тайлбар, баримтыг зохих харилцааны хэрэгсэл, эсхүл орчуулагч, хэлмэрчээр дамжуулан танилцуулах бөгөөд холбогдох журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.
- 17.6.Энэ хуульд заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтрүүлсэн бол маргагч хугацаа сэргээлгэх саналаа холбогдох баримтын хамт Цэцэд гаргаж болно. Хугацааг сэргээх журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.
- 31.1.Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах, Бага суудалд хуваарилах, Бага болон Дунд суудлын бүрэлдэхүүн, хуралдаан даргалагч, илтгэгч гишүүнийг томилох, маргааныг Дунд суудалд хуваарилах хуваарийг Цэцийн зөвлөгөөнөөс жил бүрийн 12 дугаар сард батална. Холбогдох журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.
- 37.1.Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг Бага, Дунд, Их суудлаар зохион байгуулна. Холбогдох журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна.
- 44.18.Цэцийн хуралдааны аюулгүй байдлыг хангах, даргалагчийн даалгаснаар хуралдааны дэг сахиулах үүргийг төрийн тусгай хамгаалалтын албан хаагч гүйцэтгэнэ. Энэ талаарх журмыг Цэцийн тамгын газрын дарга Төрийн тусгай хамгаалалтын газрын даргатай хамтран батална.
- 44.19.Аман хуралдаан явуулах нарийвчилсан журмыг Дэгээр зохицуулна.

Аргачлалд төрийн байгууллагын чиг үүрэгтэй холбогдох зардлыг тооцохоор заасны дагуу дараах зохицуулалтыг төрийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх зардалд нөлөөлөхгүй гэж үзэж тус тооцоонд тусгаагүй.Үүнд:

- 5.2.Дараах маргааныг хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэлийг даруй хангана:
 - 5.2.1.онц болон дайны байдал зарласан, түүнчлэн цэрэг хөдөлгөх шийдвэртэй холбогдсон;
 - 5.2.2.иргэний үндсэн эрх болон нийтийн ашиг сонирхолд ноцтой үр дагавар бий болох эрсдэлтэй, эсхүл ийм эрсдэл үүсэхээс сэргийлэх зайлшгүй шаардлага бий болсон.
- 5.3.Энэ хуулийн 5.2-т заасан тохиолдолд хэд хэдэн илтгэгч гишүүнийг томилж болно.
- 9.2.Цэцийн гишүүн асуудал, маргааныг хянан шийдвэрлэхэд санал өгөхөөс татгалзах, хуралдаанд оролцох болон бусад албан үүргээ хэрэгжүүлэхээс зайлсхийхийг хориглоно.
- 11.1.Цэцэд маргаан хянан шийдвэрлэхдээ хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсрол, эсхүл бусад шинжээр нь ялгаварлаж үл болох бөгөөд эрх тэгш байх зарчмыг баримтална.

- 12.4.Цэц шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон үйл баримтыг үндэслэн шийдвэр гаргаж болно.
- 15.2.Хуралдаанаар маргааныг хянан шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн бол бүрэлдэхүүн уг нөхцөл байдал арилах хүртэл боломжит хугацаагаар хуралдааныг хойшлуулна.
- 29.1.Цэцийн гишүүн дараах үндэслэл байвал хуралдааны бүрэлдэхүүнд оролцохоос өөрөө татгалзан гарах үүрэгтэй:
 - 29.1.1.тухайн маргааныг захиргааны байгууллага, шүүхээр хянан шийдвэрлэхэд албан үүргийн дагуу, эсхүл мэргэжлийн үүднээс оролцсон;
 - 29.1.2.өөрөө, эсхүл өөртэй нь хамаарал бүхий этгээд маргааны үндсэн оролцогч бол.
- 29.6.Энэ хуулийн 29.1-т заасан эсхүл ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй бусад үндэслэл бий болсон бол орчуулагч, хэлмэрч, шинжээч, хуралдааны нарийн бичгийн дарга өөрөө татгалзан гарах үүрэгтэй бөгөөд тэдгээрийг татгалзан гаргах хүсэлтийг хуралдааны бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.
- 34.1.Дараах тохиолдолд Цэцийн хуралдааны бүрэлдэхүүн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ:
 - 34.1.1.Цэц уялдаа холбоо бүхий өөр маргааныг хянан шийдвэрлэхээс өмнө уг маргааныг хянан шийдвэрлэх боломжгүй;
 - 34.1.2.маргааныг хянан шийдвэрлэхэд бусад шүүхээс гарах шийдвэр ач холбогдолтой бол тухайн шийдвэр гарах хүртэл хугацаагаар;
 - 34.1.3.энэ хуулийн 33.2-т заасан ажиллагаа явуулж байгаа.
- 34.2.Энэ хуулийн 34.1-т зааснаас бусад үндэслэлээр маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхийг хориглоно.
- 34.3.Түдгэлзүүлэх үндэслэл арилсан тохиолдолд хуралдааны бүрэлдэхүүн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээнэ.
- 34.4.Маргааны оролцогч эсхүл бүрэлдэхүүний гишүүн энэ зүйлд заасны дагуу маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, эсхүл сэргээх тухай саналыг хуралдааны бүрэлдэхүүн гаргаж болно.
- 35.1.Цэцийн хуралдааны бүрэлдэхүүн дараах нөхцөлд маргааныг хэрэгсэхгүй болгоно:
 - 35.1.1.өргөдөл гаргагч нас барсан бол;
 - 35.1.2.Цэцийн харьяалан шийдвэрлэх маргаан биш;
 - 35.1.3.тухайн тодорхой асуудлаарх Цэцийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа;
 - 35.1.4.өргөдөл, хүсэлт гаргагч маргааны шаардлагаасаа татгалзсан;
 - 35.1.5.маргаан бүхий хууль тогтоомж, бусад шийдвэр хүчингүй болсон.
- 35.2.Маргаан үүсгэсэн асуудал нь нийтийн ашиг сонирхолд хамааралтай гэж үзвэл энэ хуулийн 35.1.1, 35.1.4, 35.1.5-д заасан нөхцөл үүссэн эсэх, маргагч

байгаа эсэхээс үл хамааран маргааныг үргэлжлүүлэн хянан шийдвэрлэж болно.

- 44.17.Даргалагч маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу явуулах, маргааныг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шийдвэрлэх, оролцогч эрх, үүргээ хэрэгжүүлэх, эрх тэгш байх зарчмыг хангах, хуралдааны дэгийг сахиулах талаар шаардлагатай арга хэмжээ авах үүрэгтэй.
- 59.2.Цэц нь холбогдох этгээд тодорхой хугацааны дотор өргөдөлтэй холбогдуулан тайлбар гаргах боломж олгоно.
- 59.3.Өргөдөл нь хууль тогтоомж Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлыг хөндөж байгаа бол Улсын Их Хурал, Засгийн газарт тайлбар гаргах боломж олгоно.
- 59.4.Өргөдөл нь шүүхийн шийдвэрт хэрэглэсэн хууль Үндсэн хуульд нийцээгүй, эсхүл хуулийг хэрэглэхдээ үндсэн эрхийг хязгаарласан, буруу тайлбарласан тухай бол тухайн шийдвэр өөрийнх нь талд гарсан этгээдэд тайлбар гаргах боломж олгоно.

Аргачлалд төрийн байгууллагын чиг үүрэгтэй холбогдох зардлыг тооцохоор заасны дагуу дараах зохицуулалт нь маргааны оролцогчийн чиг үүрэг байх тул төрийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх зардалд нөлөөлөхгүй гэж үзэж тус тооцоонд тусгаагүй.Үүнд:

- 16.1.Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг бичгээр, эсхүл цахимаар Цэцэд гаргана.
- 16.3.Үндсэн хуулийн Жаран зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан маргаантай асуудлаар дараах этгээд иргэдийг төлөөлөн Цэцэд мэдээлэл гаргана:
 - 16.3.2.иргэн Үндсэн хуулийн холбогдох заалт зөрчигдсөн талаар тухайн чиглэлийн төрийн бус байгууллагад нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хандсан нь үндэслэлтэй бол тухайн байгууллага.
- 16.4.Энэ хуулийн 16.3.2-д заасан төрийн бус байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна:
 - 16.4.1.мэдээллийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх;
 - 16.4.2.дүрмийн зорилгын дагуу сүүлийн таваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх.
- 16.7.Хууль тогтоомжоос бусад шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх маргаантай асуудлаар Цэцэд өргөдөл, мэдээлэл гаргахдаа уг шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан, тухайн шийдвэрийг хүчингүй болгох эрх бүхий этгээд, шүүхэд хандаж шийдвэр, хариу авсан байна.
- 16.8.Үндсэн хуулийн Жаран зургаадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан маргаантай асуудлаар Цэцэд мэдээлэл гаргахдаа тухайн албан тушаалтныг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хандаж шийдвэр, хариу авсан байна..
- 17.1.Үндсэн эрхийг нь зөрчсөн гэж үзэж байгаа иргэн дараах хугацаанд өргөдөл гаргана:

- 17.1.1.хууль тогтоомж хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш таван жилийн дотор;
- 17.1.2.Үндсэн хуулийн Жаран зургаадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-т заасан хууль тогтоомжоос бусад шийдвэр гарсан өдрөөс хойш нэг жилийн дотор;
- 17.1.3.Үндсэн хуулийн Жаран зургаадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасан сонгуулийн төв байгууллагын шийдвэр гарсан өдрөөс хойш хоёр сарын дотор;
- 17.1.4.шүүхийн шийдвэр эсхүл эрх зүйн бусад актыг гардан авснаас хойш 30 хоногийн дотор.
- 17.2.Шүүхийн шийдвэрт эсхүл эрх зүйн бусад актад хэрэглэсэн хууль тогтоомж нь Үндсэн хуульд нийцээгүй тухай өргөдлийг хянан шийдвэрлэхэд энэ хуулийн 17.1.1-д заасан хугацаа хамаарахгүй.
 - 17.3.Үндсэн хуулийн Жаран зургаадугаар зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтад заасан асуудлаар дараах хугацаанд мэдээлэл гаргана:
 - 17.3.1.Энэ зүйлийн 17.1.1, 17.1.2, 17.1.3-т заасан асуудлаар тухайн хугацаанд;
 - 17.3.2.Үндсэн хуулийн Жаран зургаадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан албан тушаалтан шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй гаргаснаас хойш нэг жилийн дотор;
 - 17.3.3.Үндсэн хуулийн Жаран зургаадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т заасан асуудлаар тухайн албан тушаалтны бүрэн эрхийн хугацаанд.
 - 17.4.Хууль тогтоомж Үндсэн хууль зөрчсөн эсэх маргаантай асуудлаар хэдийд ч хүсэлт гаргаж болно.
 - 17.5.Энэ хуулийн 17.4-т зааснаас бусад маргаантай асуудлаар хүсэлт гаргах үндэслэл бий болсон өдрөөс хойш нэг жилийн хугацаанд хүсэлт гаргаж болно.
 - 18.1.Цэцэд хандан гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд дараах зүйлийг тусгана:
 - 18.1.1.өргөдөл, мэдээлэл гаргагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг, байгууллага бол түүний нэр, оршин байгаа хаяг, эсхүл хүсэлт гаргагчийн нэр, албан тушаал, хаяг;
 - 18.1.2.өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгчийн утасны дугаар, цахим хаяг;
 - 18.1.3.Үндсэн хуульд нийцээгүй гэж үзэж байгаа хууль тогтоомж, бусад шийдвэр, эрх зүйн акт, түүний заалт, эсхүл Үндсэн хууль зөрчсөн, эсхүл огцруулах, эгүүлэн татах үндэслэлтэй хэмээн үзэж байгаа албан тушаалтны нэр, шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүйн талаарх мэдээлэл;
 - 18.1.4.зөрчигдсөн гэж үзэж байгаа Үндсэн хуулийн зүйл, заалт, түүний үндэслэл, нотолгоо;
 - 18.1.5.Цэцээр шийдвэрлүүлэх маргааны шаардлага;
 - 18.1.6.өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргагчийн цахим эсхүл ердийн гарын үсэг, огноо.
 - 18.2.Өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд дараах зүйлийг хавсаргана:

18.2.1.маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгчөөр дамжуулан оролцох бол бүрэн эрхийн хүрээг тодорхойлж, төлөөлөх эрх олгосон баримт бичиг, эсхүл итгэмжлэл;

18.2.2.маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчөөр төлөөлүүлж байгаа бол төлөөлөх эрх олгож, бүрэн эрхийн хүрээг тодорхойлсон баримт бичиг;

18.2.3.Үндсэн хуульд нийцээгүй гэж үзэж байгаа хууль тогтоомж, бусад шийдвэр, эрх зүйн акт, түүний заалтын хуулбар, эсхүл Үндсэн хууль зөрчсөн, огцруулах, эгүүлэн татах үндэслэл болсон үйлдэл, эс үйлдэхүйн нотолгоо;

18.2.4.монгол хэлээс өөр хэл дээрх баримт бичгийн албан ёсны орчуулга.

- 18.3.Энэ хуулийн 18.1, 18.2-т зааснаас гадна өргөдөлд үндсэн эрхийг зөрчсөн талаар эрх бүхий этгээд, шүүхэд хандаж эцэслэн шийдвэрлүүлсэн боловч зөрчил арилаагүй гэж үзсэн үндэслэл, эсхүл шүүхийн харьяалалд хамаарахгүй шийдвэрийн талаар Цэцэд шууд хандаж байгаа тайлбараа тусган, холбогдох шийдвэр, баримтыг хавсаргана.
- 18.4.Энэ хуулийн 18.1, 18.2-т зааснаас гадна мэдээлэлд нийтийн ашиг сонирхлыг төлөөлж Цэцэд хандсан зорилго, хүрэх боломжтой үр нөлөөг тусган, энэ хуулийн 16.4-т заасан эрх бүхий этгээд болохыг нотолсон баримт бичгийн хуулбарыг хавсаргана.
- 22.2.Үндсэн оролцогч маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах үүрэг хүлээнэ:
 - 22.2.1.Цэцээс товлосон цагт хүрэлцэн ирэх;
 - 22.2.2.Цэцийн шаардсан баримтыг тогтоосон хугацаанд гаргаж өгөх;
 - 22.2.3.Цэцэд хандан гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлт, тайлбар нь бодит байдалд нийцсэн, үнэн байх;
 - 22.2.4.маргаан хянан шийдвэрлэх явцад олж мэдсэн хуулиар хамгаалагдсан нууц, хүний эмзэг мэдээллийг задруулахгүй байх;
 - 22.2.5.хуралдааны дэг, журмыг сахих;
 - 22.2.6.хуульд заасан бусад үүрэг
- 22.4.Нийтийн ашиг сонирхлын үүднээс мэдээлэл гаргасан этгээд маргаан үүсгэснээс хойш шаардлагаасаа бүрэн, эсхүл хэсэгчлэн татгалзахыг хориглоно.
- 22.5.Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэд хамтран оролцож байгаа бол Цэц тав хүртэл төлөөлөгчийг хуралдаанд оролцуулах ба төлөөлөгч нь үндсэн оролцогчийн эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.
- 23.6.Байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд нь өөрийн албан тушаал, эрх хэмжээгээ нотлох баримт бичиг, бусад этгээд нь түүнд олгосон итгэмжлэлийг Цэцэд гаргаж өгнө.

23.7.Итгэмжлэл нь дараах шаардлагыг хангасан байна:

23.7.1.итгэмжлэлд төлөөлүүлэгч өөрийн нэр, регистрийн дугаар, утасны дугаарыг бичиж, гарын үсэг зурсан байх, байгууллагын итгэмжлэлд тухайн

байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарсан байх;

23.7.2.олгосон огноог заах;

23.7.3.хуульд заасан бол нотариатаар гэрчлүүлэх;

23.7.4.ямар маргаанд хэрхэн оролцохыг тодорхой заах;

23.7.5.итгэмжлэлийг тодорхой хугацаагаар олгох бол хугацааг заах.

- 23.8.Энэ хуулийн 23.7-д заасан шаардлагыг хангаагүй итгэмжлэл хүчин төгөлдөр бус байна.
- 23.9.Хугацаа заагаагүй итгэмжлэл нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа дуусах хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 23.10.Маргааны оролцогч, эсхүл түүнийг итгэмжлэлээр төлөөлөгч маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно.
- 23.11.Төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ажиллагааг хуулийн хүрээнд явуулж, төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлийн хүрээнд энэ хуульд заасан маргааны оролцогчийн эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
- 23.12.Дараах этгээд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгчөөр оролцохыг хориглоно:
 - 23.12.1.гэрчээр оролцсон этгээд;
 - 23.12.2.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар, эсхүл ажиллаж байгаа байгууллагаа төлөөлөн тухайн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаагаас бусад тохиолдолд шүүгч, прокурор.
- 23.13.Төлөөлөл дараах үндэслэлээр дуусгавар болно:
 - 23.13.1.төлөөлөгч итгэмжлэлээс татгалзсан;
 - 23.13.2.төлөөлүүлэгч өөрийн олгосон итгэмжлэлийг хүчингүй болгосон;
 - 23.13.3.хууль, эсхүл гэрээнд өөрөөр заагаагүй бол төлөөлүүлэгч нас барсан, эсхүл эрх зүйн бүрэн чадамжгүй болсон;
 - 23.13.4.төлөөлүүлэгч байгууллага татан буугдсан.
- 23.14.Төлөөлүүлэгч итгэмжлэлээ хүчингүй болгох, төлөөлөгч итгэмжлэлээс татгалзах эрхтэй. Энэ тухай Цэцэд даруй мэдэгдэх үүрэгтэй бөгөөд мэдэгдээгүйгээс гарах үр дагаврыг төлөөлүүлэгч хариуцна
- 24.2.Маргаан хянан шийдвэрлэхэд оролцох өмгөөлөгчийн эрх нь хууль зүйн туслалцаа авч байгаа талтай байгуулсан гэрээгээр тодорхойлогдоно.
- 44.2.Хуралдааны танхимд байгаа хүн бүр Цэц болон оролцогчдод хүндэтгэлтэй хандах, хуралдааны дэгийг сахих, хуралдаан даргалагч /цаашид "даргалагч" гэх/-д захирагдах үүрэгтэй.
- 44.10.Маргааны үндсэн оролцогч гагцхүү хэлэлцэж байгаа маргаантай холбоотой асуудлаар тайлбар хийж, асуулт асууна.
- 44.11.Шинжээч хуралдаанд оролцож байгаа бол дүгнэлтийг өөрөө уншиж сонсоно.

- 44.12.Шинжээчээс тухайн хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүд болон маргааны оролцогч дүгнэлттэй нь холбогдуулан асуулт асууж болох бөгөөд шинжээч хариулах үүрэгтэй.
- 44.14.Гэрч нь тухайн хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүн болон маргааны оролцогчийн асуултад үнэн хариулах үүрэгтэй.
- 44.16.Хуралдааны төгсгөлд үндсэн оролцогч Цэцэд хандан үг хэлж болох бөгөөд хуралдаанаар шинжлээгүй баримт бичиг, бусад баримтыг иш татахгүй.
- 24.4.Өмгөөлөгч маргаан хянан шийдвэрлэхэд оролцохдоо дараах үүрэг хүлээнэ:
 - 24.4.1.хууль зүйн туслалцаа авагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан оролцох;
 - 24.4.2.Үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон өмгөөлөгч, хуульчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;
 - 24.4.3.өмгөөллийн үйл ажиллагааны явцад олж мэдсэн хуулиар хамгаалагдсан нууц, хүний эмзэг мэдээллийг задруулахгүй байх;
 - 24.4.4.үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа үйлдэл хийхгүй байх;
 - 24.4.5.үйлчлүүлэгчийн хууль бус шаардлагаас татгалзах;
 - 24.4.6.Цэцээс товлосон хугацаанд Цэцийн хуралдаанд хүрэлцэн ирэх;
 - 24.4.7.хуульд заасан бусад эрх.
- 25.2.Гэрч нь товлосон цагт хүрэлцэн ирж, маргаантай холбогдсон асуудлаар үнэн мэдүүлэх үүрэгтэй бөгөөд шаардлагатай тэмдэглэл, баримт бичиг, мэдээ сэлтийг ашиглаж болно.
- 26.3.Шинжээч нь Цэцийн товлосон цагт хүрэлцэн ирэх, тогтоосон хугацаанд үнэн зөв, бүрэн, үндэслэл бүхий дүгнэлт гаргах үүрэгтэй.
- 26.7.Шинжээч өөрийн хийсэн ажиллагаа, шинжилгээ, түүний үндсэн дээр хүрсэн дүгнэлтээ тодорхойлохын хамт Цэцийн гишүүнээс тавьсан асуултад нэг бүрчлэн үндэслэл бүхий тодорхой хариулт өгч дүгнэлтээ бичгээр үйлдэнэ.
- 26.8.Шинжээч Цэцийн гишүүний тавьсан асуултад тусгагдаагүй боловч маргааныг шийдвэрлэхэд зайлшгүй ач холбогдолтой байж болох нөхцөл байдлыг олж тогтоовол энэ талаар дүгнэлтдээ тусгаж болно.
- 26.9.Хэд хэдэн этгээдийг баг болгон шинжээчээр томилсон бол тэд санал нэгтэй байвал нэг дүгнэлт гаргаж гарын үсгээ зурах бөгөөд харин аль нэг шинжээч санал нийлэхгүй байвал дүгнэлтээ тусдаа гаргаж болно.
- 27.2.Орчуулагч, хэлмэрч товлосон цагт хүрэлцэн ирж, өргөдөл, мэдээлэл, хүсэлт, тайлбар, мэдүүлэг, баримттай танилцах, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, Цэцийн шийдвэрийн агуулгыг үнэн зөв, бүрэн орчуулж, хэлмэрчлэх үүрэгтэй.
- 27.4.Маргааны оролцогч нь орчуулагч, хэлмэрчийн үүрэг давхар гүйцэтгэхийг хориглоно.

- 29.7.Энэ хуулийн 29.1, 29.6-д заасан татгалзан гарах үндэслэл байвал Цэцийн гишүүн, орчуулагч, хэлмэрч, шинжээч, хуралдааны нарийн бичгийн дарга Цэцийн хуралдаан эхлэхээс өмнө тухайн хуралдаан даргалагчид бичгээр, эсхүл татгалзан гарах үндэслэл хуралдаан эхлэх хүртэл мэдэгдээгүй, хуралдааны явцад илэрсэн бол энэ тухайгаа мэдсэн даруй хуралдаан даргалагчид мэдэгдэж, татгалзан гарах үүрэгтэй.
- 44.2.Хуралдааны танхимд байгаа хүн бүр Цэц болон оролцогчдод хүндэтгэлтэй хандах, хуралдааны дэгийг сахих, хуралдаан даргалагч /цаашид "даргалагч" гэх/-д захирагдах үүрэгтэй.
- 44.12.Шинжээчээс тухайн хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүд болон маргааны оролцогч дүгнэлттэй нь холбогдуулан асуулт асууж болох бөгөөд шинжээч хариулах үүрэгтэй.
- 44.14.Гэрч нь тухайн хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүн болон маргааны оролцогчийн асуултад үнэн хариулах үүрэгтэй.
- 53.2.Цэцийн шийдвэрийг нийт байгууллага, албан тушаалтан, иргэн, хэн боловч заавал биелүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 1. Зардалд нөлөөлөх зүйл, заалт

Хуулийн төслийн төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл, заалт
4 дүгээр зүйл. Маргаан хянан шийдвэрлэх хүрээ 4.2.Цэц энэ хуульд өөрөөр заагаагүй бол хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, бусад шийдвэр, эсхүл бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотой, Цэцийн харьяалалд хамаарах маргааныг хянан шийдвэрлэнэ.	4.3.Хүчингүй болсон хууль тогтоомж, бусад шийдвэр нь Үндсэн хуульд нийцээгүй байсан гэдгийг тогтоолгох ашиг сонирхол өргөдөл гаргагчид бий гэж үзвэл уул маргааныг хянан шийдвэрлэхэд энэ хуулийн 4.2 хамаарахгүй. 7.2.Цэцэд маргаан хянан шийдвэрлэх зардалд дараах зүйлийг хамааруулна: 7.2.1.шинжээч, орчуулагч, хэлмэрчийн тээвэр, байр, хоолны зардал, Цэцийн шийдвэрээр гүйцэтгэсэн ажил үндсэн чиг үүрэгт нь хамаарахгүй бол ажлын хөлс; 7.2.2.гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, цалин, хөдөлмөрийн хөлс; 7.2.3.хөгжлийн бэрхшээлтэй оролцогчийг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах зардал; 7.2.4.шаардлагатай бусад ажиллагааг гүйцэтгэсний зардал. 7.3.Маргаан хянан шийдвэрлэх зардлыг дараах журмаар тодорхойлно: 7.3.1.шинжээч, орчуулагч, хэлмэрч, гэрчид олгох тээвэр, байр, хоолны зардлыг улсын төсвөөс санхүүждэг байгууллагад мөрдөгдөж байгаа албан томилолтын зардлын хэмжээгээр;

	7.3.2. шинжээч, орчуулагч, хэлмэрчийн ажлын хөлсийг жишиг үнэлгээг харгалзан тогтоосон хэмжээгээр; 7.3.3. мэдүүлэг өгөхөөр Цэцэд дуудагдсан хугацаанд гэрч цалин, хөдөлмөрийн хөлсөөр хохирсон бол энэ хугацааны цалин, хөдөлмөрийн хөлсний дунджаар; 7.3.4. хөгжлийн бэрхшээлтэй оролцогчийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахад шаардлагатай хэрэгсэл, тоног төхөөрөмж ашигласны төлбөрөөр; 7.3.5. бусад зардлыг зохих журмын дагуу. 10.5. Хуульд өөрөөр заагаагүй бол аман хуралдааны явцыг дууны болон дуу-дүрсний бичлэгээр зохих журмын дагуу баталгаажуулж, архивд хадгална. 11.2. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн энэ хуульд заасан эрхээ хэрэгжүүлэхэд Цэц дэмжлэг үзүүлнэ. 12.1. Цэц маргааныг Үндсэн хуульд нийцүүлэн бүрэн гүйцэд, бодитой хянан шийдвэрлэхэд шаардлагатай ажиллагааг явуулж, ач холбогдол бүхий баримтыг цуглуулах, үнэлэх үүрэгтэй. 12.2. Цэц маргааныг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой баримтыг хүн, албан тушаалтан, байгууллагаас гаргаж өгөхийг шаардах эрхтэй ба холбогдох этгээд заасан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй. 16.3. Үндсэн хуулийн Жаран зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан маргаантай асуудлаар дараах этгээд иргэдийг төлөөлөн Цэцэд мэдээлэл гаргана: 16.3.1. иргэнээс Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 20.1-т заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комисст гаргасан асуудал иргэний үндсэн эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй бол түүнийг тогтоолгохоор Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн; 19.1. Цэцэд хандан гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцийн Тамгын газар /цаашид "Тамгын газар" гэх/ хүлээн авна. 19.2. Ерөнхий бүртгэгч нь өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг энэ хуулийн 16, 17, 18 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Цэц урьд нь тухайн асуудлыг шийдвэрлэсэн эсэхийг нягтлан үзэж, тухайн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцэд ирүүлснээс хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх бүртгэлд бүртгэсэн эсэх талаар үндэслэл бүхий хариуг маргагчид өгнө. Холбогдох журмыг Дэгээр нарийвчлан зохицуулна. 19.3. Ерөнхий бүртгэгч дараах тохиолдолд өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг маргагчид буцаана: 19.3.1. энэ хуулийн 16, 17, 18 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй; 19.3.2. Цэцээс урьд өмнө нь хариу өгсөн асуудлаар дахин өргөдөл, мэдээлэл гаргасан бөгөөд түүнийг дахин нягтлан үзэх үндэслэлгүй бол. 19.4. Ерөнхий бүртгэгчээс өгсөн хариуг маргагч эс зөвшөөрвөл 30 хоногийн дотор өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцэд дахин ирүүлж болно. 19.5. Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг энэ хуульд заасан шаардлага хангаж, эсхүл түүнийг энэ хуулийн 16.9, 19.4-т
--	--

	заасны дагуу гаргасан бол Ерөнхий бүртгэгч ажлын таван өдрийн дотор Цэцийн зөвлөгөөнөөс тогтоосон хуваарь, Дэгд заасны дагуу Бага суудлын бүрэлдэхүүнд гардуулж, хянан шийдвэрлэх бүртгэлд бүртгэнэ. 20.1.Тамгын газар өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг албан хэрэг хөтлөх журмын дагуу бүртгэж, цахим сан үүсгэнэ. 20.2.Цэцийн шийдвэрийн хуулбар, эсхүл маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах баримт бичгийг маргааны оролцогчдод цахимаар хүргүүлнэ. 20.3.Маргааны оролцогч Цэцийн шийдвэр, холбогдох баримт бичгийг бичгээр авах хүсэлт гаргасан, эсхүл цахим үйлчилгээ үзүүлэх боломжгүй тохиолдолд маргааны оролцогчид шийдвэр, баримт бичгийг шуудангаар хүргүүлнэ. 25.1.Маргаан хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдал, үйл баримтыг мэдэж байгаа этгээдийг илтгэгч гишүүн эсхүл хуралдааны бүрэлдэхүүн гэрчээр оролцуулж болно. 26.4.Шинжээч санаатай худал дүгнэлт гаргах, дүгнэлт гаргахаас хууль бусаар зайлсхийсэн, татгалзсан тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэх талаар сануулж, Дэгд заасны дагуу баримтжуулна. 28.1.Цэцийн хуралдааны нарийн бичгийн дарга нь маргааны оролцогчдод маргаан хянан шийдвэрлэхэд оролцох эрх, үүргийг танилцуулан баталгаажуулах, хуралдаан явуулах нөхцөлийг хангах, маргааны оролцогчдод товыг мэдэгдэх, тэдний ирцийг бүртгэж, танилцуулах, хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнд гарын үсэг зурж, даргалагчаар баталгаажуулж маргааны материалд хавсаргах, шаардлагатай бусад ажиллагааг гүйцэтгэнэ.
30 дугаар зүйл.Маргаан хянан шийдвэрлэх үндэслэл 30.1.Цэц гагцхүү энэ хуульд заасан журмын дагуу гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг үндэслэн маргааныг хянан шийдвэрлэнэ.	31.2.Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах, Бага суудалд хуваарилах, Бага болон Дунд суудлын бүрэлдэхүүн, хуралдаан даргалагч, илтгэгч гишүүнийг томилох, маргааныг Дунд суудалд хуваарилах журам нь урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан байх бөгөөд дараах шаардлагыг хангасан программ хангамжийг ашиглана: 31.2.1.Цэц өргөдөл, мэдээлэл, хүсэлт, гомдлыг хүлээн авсан даруй хуваарилалтыг хийх, Зөвлөгөөний шийдвэргүйгээр өөрчлөх боломжгүй хамгаалалттай байх, хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг оролцогч этгээдэд шууд өгөх боломжтой байх; 31.2.2.цахимаар хийгдсэн хуваарилалтыг гагцхүү энэ хуульд заасны дагуу татгалзан гаргах, гарах хүсэлтийг үндэслэлтэй гэж үзсэн, эсхүл Цэцийн гишүүн, тухайн хуралдааны бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөх бөгөөд уг өөрчлөлт нь хүний нөлөөллөөс ангид, ил тод, баримтжуулсан байх. 31.3.Энэ хуулийн 31.1, 31.2-т заасан хуваарь, журмын дагуу өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах, Бага суудалд хуваарилах, Бага болон Дунд суудлын бүрэлдэхүүн, хуралдаан даргалагч, илтгэгч гишүүнийг томилох бөгөөд маргааныг Дунд суудалд хуваарилна.

	32.1.Бүх шатны шүүх, захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтан, холбогдох этгээд шаардлагатай баримт, мэдээллийг Цэцэд саадгүй гаргаж өгөх, Цэцэд маргаан хянан шийдвэрлэхэд үйл ажиллагаа, эх сурвалжаараа дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. 32.2.Бүх шатны шүүх, захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтны гаргаж өгсөн эх баримтыг тэдний бичгээр гаргасан саналын дагуу маргаан хянан шийдвэрлэж дууссаны дараа буцаан өгч болно. Эх баримтыг буцаан өгсөн тохиолдолд хуулбар болон зохих журмын дагуу бэхжүүлсэн хувилбарыг маргааны материалд хавсаргана. 33.1.Хуралдааны бүрэлдэхүүн маргааны оролцогч эсхүл бүрэлдэхүүний гишүүний саналаар маргааны талаар баримт бүрдүүлэх шаардлагатай гэж үзвэл тодорхой ажиллагаа гүйцэтгэхийг зохих шүүхэд даалгаж болно. 33.2.Энэ хуулийн 33.1-т заасан Цэцийн даалгаварт маргааны товч агуулга, явуулбал зохих ажиллагаа, бүрдүүлэх баримтыг зааж, даалгавар биелүүлэх хугацааг тогтоох бөгөөд энэ хугацаанд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ. 33.3.Даалгавар хүлээн авсан шүүх тогтоосон хугацаанд түүнийг биелүүлж, хөтөлсөн тэмдэглэл, бүрдүүлсэн баримтыг Цэцэд хүргүүлнэ. 36.2.Аман хуралдааны тэмдэглэлд дараах зүйлийг тусгах бөгөөд мэдээллийн технологийн хэрэгсэл ашиглаж болно. 36.4.Аман хуралдааны тэмдэглэлийг хуралдаан дууссан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор бичгээр үйлдэж, хуралдаан даргалагч болон нарийн бичгийн даргын гарын үсэг зурж баталгаажуулан маргааны материалд хавсаргана.
37.2.Бага суудал гурав, Дунд суудал зургаа, Их суудал нийт гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар энэ хуульд заасны дагуу маргааныг хянан шийдвэрлэнэ. 39.1.Цэц өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар, эсхүл хүсэлтийн дагуу маргаан үүсгэх эсэхийг Бага суудлын хуралдаанаар шийдвэрлэнэ. 39.4.Цэцэд өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргах хугацааг сэргээлгэх саналыг Бага суудлын хуралдаанаар түүнийг Цэцэд ирүүлснээс хойш 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.	39.2.Бага суудлын хуралдаан зөвлөлдөх хэлбэртэй байна. 39.3.Бага суудлын бүрэлдэхүүн Цэцэд маргаан үүсгэх эсэх эсхүл энэ хуульд заасан бусад асуудлыг олонхын саналаар шийдвэрлэж, магадлал гаргана. 40.1.Энэ хуулийн 19.5-д заасны дагуу өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг гардуулснаас хойш долоо хоногийн дараа 30 хоногийн дотор Бага суудлын хуралдааныг хийнэ. Бага суудлын бүрэлдэхүүн шаардлагатай тохиолдолд уул хугацааг 30 хоногоор нэг удаа сунгаж болно. 40.2.Бага суудлын хуралдаан даргалагч нь бүрэлдэхүүний бусад гишүүнтэй зөвшилцөн хуралдааныг товлож, захирамж гаргана. 40.3.Өргөдөл, мэдээлэл, хүсэлт нь Цэцэд хянан шийдвэрлэж байгаа өөр маргаантай уялдаа холбоотой, эсхүл нэмж судлах шаардлагатай гэж үзвэл Бага суудал хуралдааныг хойшлуулна. 41.1.Бага суудлын бүрэлдэхүүн доор дурдсан үндэслэл байвал маргаан үүсгэхээс татгалзаж магадлал гаргана. 41.1.1.Цэцийн харьяалан шийдвэрлэх асуудал биш;

	41.1.2.өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргах эрх бүхий этгээд биш, эсхүл түүнийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд гаргасан; 41.1.3.эрх зүйн бүрэн чадамжгүй хүн өргөдөл гаргасан, эсхүл түүнийг төлөөлөх этгээд байхгүй; 41.1.4.өргөдөл, мэдээлэл, хүсэлт нь энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй; 41.1.5.энэ хуульд заасан хугацаа өнгөрсөн; 41.1.6.хуульд заасан урьдчилан шийдвэрлүүлэх журмыг зөрчсөн; 41.1.7.Цэцийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа; 41.1.8.Үндсэн хуулийн эрх зүйн маргааны шинжийг агуулаагүй; 41.1.9.Үндсэн хуулийн суурь ач холбогдолгүй; 41.1.10.өргөдөл, мэдээлэл гаргагч маргааны шаардлагаасаа татгалзсан. 41.2.Энэ хуулийн 41.1-т заасан үндэслэлийг магадлалд товч заах бөгөөд магадлал нь маргаан үүсгэх эсэх талаарх эцсийн шийдвэр болно. 41.3.Маргаан үүсгэснээс хойш ажлын таван өдрийн дотор энэ тухай цахим хуудас болон бусад хэрэгслээр нийтэд мэдээлнэ. 41.4.Маргаан үүсгэсэн тохиолдолд энэ хуулийн 31.2-т заасан журмын дагуу илтгэгч гишүүнийг томилно.
42.1.Хуульд өөрөөр заагаагүй бол маргаан үүсгэж шалгасан маргаантай асуудлыг Дунд суудлын хуралдаанаар олонхын саналаар шийдвэрлэж, дүгнэлт гаргана.	42.2.Дунд суудлын бүрэлдэхүүн энэ хуулийн 42.1-т зааснаас бусад асуудлыг зөвлөлдөх хуралдаанаар хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэж, магадлал гаргана. 43.1.Илтгэгч гишүүн маргааныг хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангаж, шаардлагатай бол дараах ажиллагааг явуулна: 43.1.1.холбогдох байгууллага, албан тушаалтан, бусад этгээдээс маргааныг шийдвэрлэхэд ач холбогдолтой тайлбар, лавлагаа, бусад баримтыг гаргуулах; 43.1.2.гэрчээр дуудах; 43.1.3.шинжээч томилон дүгнэлт гаргуулах; 43.1.4.маргаан үүсгэсэн магадлалыг үндсэн оролцогчдод танилцуулах, маргаанд холбогдуулан тайлбар, нэмэлт тодруулга авах; 43.1.5.маргаантай адил агуулга бүхий өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг нэгтгэн шалгах, нэг хуралдаанаар шийдвэрлэх боломжгүй шаардлагыг тусгаарлах санал гаргах; 43.1.6.энэ хуулийн 34.1-т заасан үндэслэлээр маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, сэргээх санал гаргах; 43.1.7.энэ хуулийн 35.1-т заасан үндэслэлээр маргааныг хэрэгсэхгүй болгох санал гаргах; 43.1.8.энэ хуульд заасан үндэслэлээр маргаан хянан шийдвэрлэх хугацааг сунгуулах санал гаргах; 43.1.9.хуульд заасан бусад ажиллагаа явуулах. 43.2.Энэ хуулийн 43.1.5, 43.1.6, 43.1.7, 43.1.8-т заасан илтгэгч гишүүний саналыг бүрэлдэхүүн зөвлөлдөх хуралдаанаар шийдвэрлэнэ.

	43.3.Маргааны үндсэн оролцогч энэ хуулийн 43.1-т заасан ажиллагаа явуулах саналыг илтгэгч гишүүнд гаргах эрхтэй. Илтгэгч гишүүн уул саналаас татгалзсан тохиолдолд маргааны үндсэн оролцогчийн гомдлоор хуралдааны бүрэлдэхүүн шийдвэрлэнэ. 43.4.Маргааныг хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангагдсан бол илтгэгч гишүүн хуралдааны бүрэлдэхүүнтэй зөвшилцөн хуралдааны товыг тогтооно. Бүрэлдэхүүний шийдвэрт хуралдаан болох газар, огноо, цаг, хуралдаан нээлттэй, эсхүл хаалттай хийх болон зөвлөлдөх, эсхүл аман хэлбэрээр явуулахыг тодорхойлно. 43.5.Илтгэгч гишүүн цугларсан баримтыг хуралдаан болохоос 21-ээс доошгүй хоногийн өмнө хуралдааны бүрэлдэхүүнд хуулбарлан тараана. Хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүн маргааны материалтай танилцах эрхтэй. 43.6.Хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүн энэ хуулийн 43.5-д заасны дагуу баримтыг хүлээн авснаас хойш ажлын арван өдрийн дотор нэмэлт ажиллагаа хийлгэх санал гаргаж болох бөгөөд тухайн бүрэлдэхүүн уг саналыг хүлээн авсан бол энэ хуульд заасны дагуу хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэх хугацааг сунгана. 43.7.Аман хуралдаан болохоос арваас доошгүй ажлын өдрийн өмнө хуралдаан болох газар, огноо, цагийг маргааны оролцогчдод мэдэгдэж, Цэцийн цахим хуудас болон бусад хэрэгслээр нийтэд мэдээлнэ. 43.8.Энэ хуулийн 5.2-т заасан тохиолдолд аман хуралдаан болохоос таваас доошгүй ажлын өдрийн өмнө энэ хуулийн 43.7-т заасны дагуу мэдэгдэж, мэдээлнэ.
48.1.Их суудлын хуралдаанаар дараах маргааныг хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэнэ: 48.1.1.Улсын Их Хурал энэ хуулийн 47.3, 47.4-т заасан хугацаанд Цэцийн дүгнэлтийг хэлэлцэж хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл уул хугацаанд зохих шийдвэр гаргаагүй бол; 48.1.2.Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль, бусад шийдвэрийн заалтыг шууд, эсхүл агуулгаар нь дахин сэргээсэн эсэх асуудлаар гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн дагуу Бага суудлын хуралдаан маргаан үүсгэсэн бол; 48.1.3.Үндсэн хуулийн тодорхой зүйл, заалтын талаарх Цэцийн эрх зүйн	48.2.Их суудал Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан маргаантай асуудлыг аман хуралдаанаар олонхын саналаар шийдвэрлэнэ. 48.3.Их суудлын хуралдааныг Цэцийн нийт гишүүний бүрэлдэхүүнтэй хийх бөгөөд хуульд заасан үндэслэлээр татгалзсан, эсхүл эрүүл мэндийн шалтгаанаар оролцох боломжгүй болсон бол Их суудлын хуралдааныг долоогоос доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй явуулж болно. 49.1.Энэ хуулийн 48.1-т заасан үндэслэл бүрдсэн бол Их суудлын хуралдааны товыг тогтооно. 49.2.Маргааныг Их суудлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэх, хэлэлцэхэд энэ хуульд заасан Дунд суудлын хуралдааны нийтлэг журмыг баримтална. 49.3.Их суудлын хуралдаан энэ хуулийн 48.1.1-т заасан үндэслэлээр маргааныг дахин хянан үзэж, эцсийн шийдвэр гаргана. 49.4.Их суудлын хуралдаанаас Үндсэн хууль зөрчсөн тухай шийдвэр гаргавал дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй Улсын Их Хурлын шийдвэрийг хүчингүй болох, эсхүл Үндсэн хууль зөрчөөгүй тухай шийдвэр гаргавал Цэцийн дүгнэлтийг хүчингүй болгоно.

байр суурийг өөрчлөх, шинээр тогтоох шаардлага үүссэн гэж Дунд суудлын хуралдаанд оролцсон гишүүдийн гурваас доошгүй нь үзсэн; 48.1.4.энэ хуулийн 59.1, 60.3-т заасан маргаан.	49.5.Их суудлын хуралдаанаар энэ хуулийн 48.1.2, 48.1.4-т заасан маргааныг хэлэлцэж, олонхын саналаар эцэслэн шийдвэрлэнэ. 49.6.Их суудлын хуралдаанаар энэ хуулийн 48.1.3-т заасан маргааныг хэлэлцэж, олонхын саналаар дүгнэлт гаргаж, энэ хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хуралд оруулна.
53 дугаар зүйл.Цэцийн шийдвэрийг заавал биелүүлэх, нийтэд мэдээлэх, хүргүүлэх, нийтлэх.	51.1.Цэцийн шийдвэрийн үндэслэх болон бусад хэсгийн төслийг хуралдааны бүрэлдэхүүний олонхоор дэмжсэн саналд үндэслэн хуралдаан болсноос хойш 14 хоногийн дотор илтгэгч гишүүн эсхүл бүрэлдэхүүний томилсон өөр гишүүн бичиж хуралдааны бүрэлдэхүүнд танилцуулна. Бүрэлдэхүүний бусад гишүүн саналаа бичиж, танилцуулах эрхтэй. 51.2.Хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүн бүр энэ хуулийн 51.1-т заасан төсөлд холбогдуулан саналаа бичгээр өгөх үүрэгтэй. 53.1.Цэцийн шийдвэр гармагцаа эсхүл хуралдааны бүрэлдэхүүн шийдсэн тохиолдолд цахим хуудаст нийтэлснээр хүчин төгөлдөр болно. 53.4.Шаардлагатай гэж хуралдааны бүрэлдэхүүн үзсэн тохиолдолд Цэцийн шийдвэрийг нийтэд танилцуулах өдрийг товлож, шийдвэрийн агуулгыг Тамгын газар нийтэд мэдээлнэ. 53.6.Цэцийн шийдвэрийг ёсчилсноос хойш ажлын таван өдрийн дотор маргааны оролцогч болон Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. 53.7.Цэцийн дүгнэлт, тогтоолыг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтэлнэ. 53.8.Жил бүрийн нэгдүгээр сард багтаан өмнөх жилд маргаан хянан шийдвэрлэсэн дүгнэлт, тогтоолыг бүрэн эхээр нь Цэцийн шийдвэрийн эмхэтгэлд нийтэлнэ. Цэцийн гишүүн шаардлагатай гэж үзвэл тусгай саналаа тогтоол, дүгнэлтийн хамт Цэцийн шийдвэрийн эмхэтгэлд нийтлүүлнэ. 53.10.Цэцийн шийдвэрийг ёсчилсон өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор Цэцийн дүгнэлт, тогтоол, тусгай саналыг бүрэн эхээр нь цахим хуудсанд байршуулж, нийтэлнэ. 53.11.Энэ хуулийн 52.5, 55.1-т заасан магадлалыг энэ зүйлд заасны дагуу нийтэд мэдээлж, хүргүүлж, Төрийн мэдээлэл болон Цэцийн шийдвэрийн эмхэтгэлд нийтлэх бөгөөд цахим хуудаст байршуулна. 55.3.Түр түдгэлзүүлэх тухай магадлал гаргасан шийдвэрээ үндэслэл дурдахгүйгээр олон нийтэд мэдээлнэ. Энэ тохиолдолд магадлалын үндэслэлийг тусад нь маргааны үндсэн оролцогчид заавал хүргүүлнэ. 58.5.Цэц дүгнэлтдээ дараах асуудлын үндэслэлийг тодорхой бичнэ: 58.5.1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн,

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор нь шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүйгээрээ Үндсэн хууль зөрчсөн эсэх;
58.5.2.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд Үндсэн хууль эсхүл бусад хууль зөрчсөн нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл болох эсэх.

59.7.Шийдвэр Үндсэн хууль зөрчсөн талаар гаргасан өргөдлийг үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн бол Цэц хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны уг шийдвэрийг хүчингүй болгох ба уг асуудлыг Үндсэн хуульд нийцүүлэн дахин шийдвэрлүүлэхээр харьяалах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлнэ. Шүүхийн шийдвэрийн үйлчлэлийг түдгэлзүүлэн Үндсэн хуульд нийцүүлэн шийдвэрлүүлэхээр Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3- т зааснаар Улсын дээд шүүхэд шилжүүлнэ.

59.8.Энэ зүйлийн 59.7-д заасан шийдвэрийг хүлээн авсан шүүх, эрх бүхий байгууллага, албан тушаалтан иргэний үндсэн эрхийг сэргээх, эсхүл хуулийн дагуу зүй ёсоор хэрэгжүүлэх, цаашид зөрчигдөхөөс сэргийлэх арга хэмжээ авч, холбогдох шийдвэрийг бүрэн эрхийнхээ хүрээнд гаргах үүрэгтэй.

59.9.Хууль тогтоомж Үндсэн хууль зөрчсөн талаар гаргасан өргөдлийг үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн бол тухайн хууль тогтоомжийг Цэц хүчингүй болгоно.

60.3.Энэ хуулийн 60.1-т заасан өргөдлөөр маргаан үүсгэснээс хойш дөрвөн сарын дотор Их суудлын хуралдаанаар хянан шийдвэрлэж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

61 дүгээр зүйл.Ард нийтийн санал асуулга, сонгуульд холбогдох маргаантай асуудал

61.1.Улсын Их Хурлын гишүүн нь ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний, эсхүл Ерөнхийлөгчийн сонгуулийн талаарх сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх маргаантай асуудлаар Цэцэд хүсэлт гаргаж болно.

61.2.Энэ хуулийн 61.1-т заасан хүсэлтийг санал асуулга, эсхүл тухайн сонгуулийн дүнг танилцуулсан өдрөөс хойш хоёр сарын дотор гаргана. 61.3.Энэ хуулийн 61.1-т заасан хүсэлтийг дараах үндэслэлээр гаргана:

61.5.Цэц энэ хуулийн 61.1-т заасан хүсэлтээр маргаан үүсгэснээс хойш дөрвөн сарын дотор хянан шийдвэрлэж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

61.5.1.энэ хуулийн 61.3.1-т заасан маргаантай асуудлыг хэлэлцээд сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хууль зөрчсөнийг тогтоох бөгөөд шаардлагатай тохиолдолд сонгуулийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгох;

61.5.2.энэ хуулийн 61.3.2-т заасан маргаантай асуудлыг хэлэлцээд Үндсэн хуулийн зөрчлийг тогтоох бөгөөд шаардлагатай тохиолдолд Улсын Их Хурлын гишүүний суудал хуваарилалтыг

	зөвтгөх, эсхүл тухайн тойргийн сонгуулийг хүчингүй болгох; 61.5.3.маргаантай асуудлын хүрээнд Үндсэн хууль зөрчигдсөн гэдгийг тогтоох; 61.5.4.маргаантай асуудлыг хэрэгсэхгүй болгох. 61.6.Энэ хуулийн 61.1-т заасан хүсэлтийг энэ хуулийн 56.3, 56.6-т заасны дагуу хянан шийдвэрлэнэ.
--	---

2.1. Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;
2. Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Хэрэгжүүлэх, хэмжих боломжтой чиг үүргийг хамруулах.

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Иймд Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хүрээнд төрийн байгууллагаас хэрэгжүүлэх бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоонд хамааруулан тооцдоггүй бөгөөд стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо ерөнхий байдлаар бүлэглэн тодорхойлов.

Хүснэгт 2. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа
Үндсэн хуулийн цэц	Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулах, хуралдааны товыг нийтэд мэдээлэх, тэмдэглэн хөтөлж, хадгалах, Цэцийн шийдвэр гаргах, нийтэд мэдээлэх, дүгнэлт, тогтоолыг нийтлэх.	- Маргаан үүсгэх эсэхийг шийдвэрлэх; - Маргааныг хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах; - Цэцэд өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргах хугацааг сэргээлгэх саналыг Бага суудлын хуралдаанаар түүнийг Цэцэд ирүүлснээс хойш 14 хоногийн дотор шийдвэрлэх; - Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг Бага, Дунд, Их суудлаар зохион байгуулах; - Шинжээч, орчуулагч, хэлмэрч оролцуулах; - Гэрч оролцуулах; - Хуралдааны явцыг дууны болон дуу дүрсний бичлэгээр зохих журмын дагуу баталгаажуулж, архивд хадгалах; - Цэцийн шийдвэрийг нийтэд мэдээлэх;

		- Цэцийн дүгнэлт, тогтоолыг нийтлэх.
	Цэцийн шийдвэр, Цэцийн гишүүний тусгай саналыг нийтэд мэдээлэх, хүргүүлэх, цахим хуудаст байршуулах, эмхэтгэн хэвлэх, хайлт хийх боломжтой цахим сан бүрдүүлэх, тогтмол шинэчлэх;	- Цэцийн шийдвэр, Цэцийн гишүүний тусгай саналыг нийтэд мэдээлэх; - Цэцийн шийдвэр, Цэцийн гишүүний тусгай саналыг эмхэтгэн хэвлэх; - Цэцийн шийдвэр, Цэцийн гишүүний тусгай саналыг хайлт хийх боломжтой цахим сан төвлөрүүлэх, тогтмол шинэчлэх.
	Тамгын газар нь Цэцэд хандан гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах.	- Цэцэд хандан гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах; - Тамгын газар өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг албан хэрэг хөтлөх журмын дагуу бүртгэх; - Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг цахим сан үүсгэх; - Цэцийн шийдвэрийн хуулбар, эсхүл маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах баримт бичгийг маргааны оролцогчдод цахимаар хүргүүлэх; - Маргааны оролцогч Цэцийн шийдвэр, холбогдох баримт бичгийг бичгээр авах хүсэлт гаргасан, эсхүл цахим үйлчилгээ үзүүлэх боломжгүй тохиолдолд маргааны оролцогчид шийдвэр, баримт бичгийг шуудангаар хүргүүлэх; - Цэцийн шийдвэрийн агуулгыг нийтэд мэдээлэх.
	Ерөнхий бүртгэгч нь өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг нягтлан үзэж, Цэцээр хянан шийдвэрлэх бүртгэлд бүртгэсэн эсэх талаар үндэслэл бүхий хариуг маргагч этгээдэд өгөх.	- Ерөнхий бүртгэгч нь өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг нягтлан үзэх; - Цэцээр хянан шийдвэрлэх бүртгэлд бүртгэсэн эсэх талаар үндэслэл бүхий хариуг бэлтгэх; - Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг шаардлага хангаагүй, нягтлан үзэх үндэслэлгүй бол маргагчид буцаах; - Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг энэ хуульд заасан шаардлага хангаж, эсхүл түүнийг энэ хуулийн 16.9, 19.4-т заасны дагуу гаргасан бол ажлын таван өдрийн дотор Цэцийн зөвлөгөөнөөс тогтоосон хуваарь, Дэгд заасны дагуу Бага суудлын бүрэлдэхүүнд гардуулж, хянан шийдвэрлэх бүртгэлд бүртгэх; - Хариуг маргагч этгээдэд өгөх, танилцуулах.

	Цэцийн хуралдааны нарийн бичгийн дарга нь маргааны оролцогчдод товыг мэдэгдэх, хуралдаан явуулах нөхцөлийг хангах, хуралдааны тэмдэглэл хөтлөх.	- Маргааны оролцогчдод маргаан хянан шийдвэрлэхэд оролцох эрх, үүргийг танилцуулан баталгаажуулах; - Хуралдаан явуулах нөхцөлийг хангах; - Маргааны оролцогчдод товыг мэдэгдэх. - Маргааны оролцогчдын ирцийг бүртгэж, танилцуулах; - Хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнд гарын үсэг зурж, даргалагчаар баталгаажуулж маргааны материалд хавсаргах; - Маргаан хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой бол гадаад хэлээр гаргасан тайлбар, мэдүүлгийг Цэцийн хуралдааны тэмдэглэлд хавсаргах.
Шүүх	Шүүх нь шаардлагатай баримт бүрдүүлэх, мэдээллийг гаргаж өгөх, дэмжлэг үзүүлэх.	- Шүүх, Захиргааны байгууллага, Албан тушаалтан, холбогдох этгээд шаардлагатай баримт, мэдээллийг Цэцэд гаргаж өгөх; - Цэцэд маргаан хянан шийдвэрлэхэд үйл ажиллагаа, эх сурвалжаараа дэмжлэг үзүүлэх; - Цэц маргааны талаар баримт бүрдүүлэх шаардлагатай гэж үзвэл Шүүх тодорхой ажиллагаа гүйцэтгэх; - Даалгавар хүлээн авсан шүүх тогтоосон хугацаанд түүнийг биелүүлж, хөтөлсөн тэмдэглэл, бүрдүүлсэн баримтыг Цэцэд хүргүүлэх.
Хүний эрхийн үндэсний комисс	- Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан маргаантай асуудлаар иргэдийг төлөөлөн Цэцэд мэдээлэл гаргах	- Иргэнээс Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 20.1-т заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комисст гаргасан асуудал иргэний үндсэн эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй бол түүнийг тогтоолгохоор Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Цэцэд мэдээлэл гаргах.

2.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистиكت тоон мэдээллийг тооцсон болно.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн иргэний өргөдлөөр маргаан хянан шийдвэрлэгдэх тохиолдлын тоог тооцохдоо Улсын Дээд шүүх (цаашид, УДШ)-ийн 2022 оны маргаан шийдвэрлэсэн статистик тоог баримталлаа. Үүнд:

Хүснэгт 3. УДШ-ийн хэрэг маргаан шийдвэрлэсэн тоон үзүүлэлт /2022 он/

	Эрүүгийн хэрэг	Иргэний хэрэг	Захиргааны хэрэг
УДШ-д ирсэн гомдлын тоо	1108	2701	550
УДШ-ээс хянан шийдвэрлэсэн маргааны тоо	431	1,652	190
Тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн тохиолдлын тоо	37	401	16

Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн иргэн нь Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргахаас өмнө эрхээ сэргээлгэхээр бүх шатны шүүхийн механизмыг ашигласан байхыг шаардана. Иймд УДШ-ээс иргэний гомдлыг хүлээн авч, хянан хэлэлцээд тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн тоогоор Үндсэн хуулийн цэцийн иргэний өргөдлийг хянан шийдвэрлэх чиг үүргийн тохиолдлын тоог тооцов. УДШ-ээс 2022 онд 4,359 гомдлыг хүлээн авснаас 454 тохиолдолд нь тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн байна. Иймд дээрх тооны гомдлыг өргөдөл хэлбэрээр Үндсэн хуулийн цэц хүлээн авна гэж үзлээ.

Иргэнээс ирүүлсэн өргөдөл бүрд холбогдуулан маргаан үүсгэдэггүй тул маргаан үүсгэх магадлалыг дараах тоон мэдээлэлд үндэслэн тогтоов. Үүнд:

Хүснэгт 4. Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн мэдээлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийн тоон мэдээ /2018-2022 он/

№	Төрөл	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1.	Гомдол	33	45	37	23	36
2.	Мэдээлэл	174	137	121	133	97
3.	Өргөдөл	28	64	31	28	54
4.	Хүсэлт	4	2	-	3	-
Нийт:		237	248	189	187	187

Хүснэгт 5. Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн өргөдөл, мэдээлэл, гомдлыг тамгын газраас буцаасан байдлын тоон мэдээ

№	Өргөдөл, мэдээллийг буцаасан байдлын тоо
2022	46
2021	47
2020	46
2019	45
2018	29

Хүснэгт 6. Үндсэн хуулийн цэцийн гишүүний маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан тогтоолын тоон мэдээ

№	Үндсэн хуулийн цэцийн гишүүний тогтоолын тоо
2022	64
2021	72
2020	84
2019	91
2018	94

Дээрх статистикаас дүгнэвэл, Үндсэн хуулийн цэц жилд дунджаар 192 өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авдгаас ойролцоогоор 43-ыг буцааж, 81-т нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэхээс татгалздаг байна. Өөрөөр хэлбэл, нийт 67 өргөдлийг буюу 35 хувийг хүлээн авч шийдвэрлэдэг.

Иймд УДШ-ээс магадлал, шийдвэрийг хэвээр үлдээсэнтэй холбоотойгоор 454 иргэн Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргана гэж үзвэл, Үндсэн хуулийн цэц түүний 35 хувийг буюу 159 хэрэг шийдвэрлэнэ гэж тооцооллоо.

Харин Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг шийдвэрлэх тохиолдлын тоог тогтоохдоо Хүний эрхийн комиссын 2020, 2021, 2022 оны тайланг үндэслэв. Хүний эрхийн комисс нь 2022 онд нийт 904 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 790-г шийдвэрлэж, түүний 2-т нь иргэнийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. 2021 онд 1146 гомдол хүлээн

авснаас 1032-г шийдвэрлэж хариу өгч, түүний 2-т нь шүүхэд нэхэмжлэл гаргасан. 2020 онд 790 гомдлыг хүлээн авч, 715-г шийдвэрлэж, үүний 2-т нь шүүхэд нэхэмжлэл гаргасан. Иймд Хүний эрхийн комиссын хүсэлтээр Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэх тохиолдлын тоог 2 гэж тооцлоо. Үүн дээр бусад эрх бүхий албан тушаалтнаас жилд дунджаар 2 хүсэлт ирнэ гэж тооцоолж, хүсэлт шийдвэрлэх тохиолдлын тоог 4 гэж үзлээ.

Бусад төрлийн өргөдөл, гомдол жилд дунджаар 76 байх тул дээр дурдсан төрлийн гомдол, мэдээлэл, өргөдөл, хүсэлтийн нийт дундаж тоог 373 гэж үзэв.

Хүснэгт 7. Үндсэн хуулийн цэцийн бага, дунд, их суудлын хуралдааны тоон мэдээ

Он	Нийт хийсэн хуралдаан	Үүнээс		
		Бага суудлын хуралдааны тоо	Дунд суудлын хуралдааны тоо	Их суудлын хуралдааны тоо
2017	37	26	9	2
2018	51	27	20	4
2019	41	28	8	5
2020	43	27	15	1
2021	30	19	8	3
Нийт	202	127	60	15

Үүнээс үзэхэд 2017-2021 оны хооронд нийт шийдвэрлэгдсэн маргааны 60 буюу 30% нь дунд суудлын хуралдаанаар 7% нь их суудлын хуралдаанаар шийдэгдсэн байна. Иймд ҮХЦ бага суудлын хуралдаанаар 159 хэрэг шийдвэрлэж магадлал гаргана гэж тооцоолсон тул энэ нь нийт маргааны 63% болно. Нийт 252 маргааны 30% буюу ойролцоогоор 75 хэрэг, маргааныг дунд суудлын хуралдаанаар, 7% буюу 18 хэрэг, маргааныг их суудлын хуралдаанаар тус тус хэлэлцэж шийдвэрлэхээр байна.

Хүснэгт 8. Цэцийн стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Зарцуулах хугацаа	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
----------------------	------------------------	----------------	-------------------	------------------------------

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулах	Бага суудлын хуралдаанаар маргаан үүсгэх эсэхийг шийдвэрлэх	159	17,760 ¹	2,823,840
	Маргааныг хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах	159	17,760	2,823,840
	Цэцэд өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргах хугацааг сэргээлгэх саналыг Бага суудлын хуралдаанаар түүнийг Цэцэд ирүүлснээс хойш 14 хоногийн дотор шийдвэрлэх	159	4800	763,200
	Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулах	252	129,600	32,659,200
Цэцийн шийдвэр, Цэцийн гишүүний тусгай саналыг нийтэд мэдээлэх, хүргүүлэх, цахим хуудаст байршуулах, эмхэтгэн хэвлэх.	Цэцийн шийдвэр, Цэцийн гишүүний тусгай саналыг нийтэд мэдээлэх	1	96000	96000
	Цэцийн шийдвэр дүгнэлт, тогтоолыг нийтлэх, цэцийн гишүүний тусгай саналыг эмхэтгэн хэвлэх	1	96000	96000
	Цэцийн шийдвэр, Цэцийн гишүүний тусгай саналыг хайлт хийх боломжтой цахим сан төвлөрүүлэх, тогтмол шинэчлэх.	1	96000	96000
Тамгын газар нь Цэцэд хандан гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах.	Цэцэд хандан гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах	454	480	217,920
	Тамгын газар өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг албан хэрэг хөтлөх журмын дагуу бүртгэх.			
	Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг цахим сан үүсгэх.	1	96000	96000
	Цэцийн шийдвэрийн хуулбар, эсхүл маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах баримт бичгийг маргааны оролцогчдод цахимаар хүргүүлэх.	252	10	2520

¹ Хуулийн төслийн 40.1-т заасныг баримтлан дунджаар 7+30 хоногт /1 удаа сунгахгүй гэж үзвэл/ шийдвэрлэнэ гэж тооцов.

	Маргааны оролцогч Цэцийн шийдвэр, холбогдох баримт бичгийг бичгээр авах хүсэлт гаргасан, эсхүл цахим үйлчилгээ үзүүлэх боломжгүй тохиолдолд маргааны оролцогчид шийдвэр, баримт бичгийг шуудангаар хүргүүлэх.	126	3360	423,360
	Цэцийн шийдвэрийн агуулгыг нийтэд мэдээлэх.	252	960	241,920
Ерөнхий бүртгэгч нь өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг нягтлан үзэж, Цэцээр хянан шийдвэрлэх бүртгэлд бүртгэсэн эсэх талаар үндэслэл бүхий хариуг бэлтгэх.	Ерөнхий бүртгэгч нь өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг нягтлан үзэх.	1	96000	96000
	Цэцээр хянан шийдвэрлэх бүртгэлд бүртгэсэн эсэх талаар үндэслэл бүхий хариуг бэлтгэх.			
	Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг шаардлага хангаагүй, нягтлан үзэх үндэслэлгүй бол маргагчид буцаах.			
	Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг энэ хуульд заасан шаардлага хангаж, эсхүл түүнийг энэ хуулийн 16.9, 19.4-т заасны дагуу гаргасан бол ажлын таван өдрийн дотор Цэцийн зөвлөгөөнөөс тогтоосон хуваарь, Дэгд заасны дагуу Бага суудлын бүрэлдэхүүнд гардуулж, хянан шийдвэрлэх бүртгэлд бүртгэх.			
	Хариуг маргагч этгээдэд өгөх, танилцуулах.			
Цэцийн хуралдааны нарийн бичгийн дарга нь маргааны оролцогчдод товыг мэдэгдэх,	Маргааны оролцогчдод маргаан хянан шийдвэрлэхэд оролцох эрх, үүргийг танилцуулан баталгаажуулах;	1	96000	96000
	Маргаан хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой бол гадаад хэлээр гаргасан тайлбар, мэдүүлгийг Цэцийн			

хуралдаан явуулах нөхцөлийг хангах, хуралдааны тэмдэглэл хөтлөх.	хуралдааны тэмдэглэлд хавсаргах.			
	Хуралдаан явуулах нөхцөлийг хангах;			
	Маргааны оролцогчдод товыг мэдэгдэх.			
	Маргааны оролцогчдын ирцийг бүртгэж, танилцуулах;			
	Хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнд гарын үсэг зурж, даргалагчаар баталгаажуулж маргааны материалд хавсаргах;			
	Хуралдааны явцыг дууны болон дуу дүрсний бичлэгээр зохих журмын дагуу баталгаажуулж, архивд хадгалах			
Нийт		1819	732,970	40,531,800

Хүснэгт 9. Төрийн бусад байгууллагын стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Зарцуулах хугацаа	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Шүүх нь шаардлагатай баримт бүрдүүлэх, мэдээллийг гаргаж өгөх, дэмжлэг үзүүлэх.	Шүүх, Захиргааны байгууллага, Албан тушаалтан, холбогдох этгээд шаардлагатай баримт, мэдээллийг Цэцэд гаргаж өгөх	159	2400	381,600
	Цэцэд маргаан хянан шийдвэрлэхэд үйл ажиллагаа, эх сурвалжаараа дэмжлэг үзүүлэх			
	Цэц маргааны талаар баримт бүрдүүлэх шаардлагатай гэж үзвэл Шүүх тодорхой ажиллагаа гүйцэтгэх			

	Даалгавар хүлээн авсан шүүх тогтоосон хугацаанд түүнийг биелүүлж, хөтөлсөн тэмдэглэл, бүрдүүлсэн баримтыг Цэцэд хүргүүлэх	159	480	120,960
Иргэнээс Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 20.1-т заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комисст гаргасан асуудал иргэний үндсэн эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй бол түүнийг тогтоолгохоор Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Цэцэд мэдээлэл гаргах	Иргэний өргөдлийг хүлээн авах	2	480	960
	Иргэний өргөдлийг нягталж үзэх.	2	960	1920
	Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргах	2	480	960
	Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай, баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх.	2	480	960
Нийт		326	5280	507,360

Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд тусгасан нэмэлт чиг үүргийг гүйцэтгэхэд 40,531,800 минут шаардагдахаар байна. Гэвч энэ дүнд тооцогдсон Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны /бага, дунд, их суудлын хуралдааны процесс ажиллагаа/ хугацааг Цэцийн гишүүний тоог нэмэхгүй учир хасах ба Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зардалд давхар тооцогдох Ерөнхий бүртгэгчийн чиг үүрэг болон Цэцийн шийдвэр, Цэцийн гишүүний тусгай саналыг нийтэд мэдээлэх, хүргүүлэх, цахим хуудаст байршуулах, эмхэтгэн хэвлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн нийт 39,454,080 минутыг цаашид хасаж тооцох нь зардлын тооцоотой зарим хэсгээр давхцахаас сэргийлнэ. Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд тусгасан нэмэлт чиг үүргийг гүйцэтгэхэд тооцогдох бодит дүн **1,077,720** болно.

Харин бусад байгууллагын хувьд буюу Хүний эрхийн үндэсний комисс болон Шүүхэд шинээр үүссэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд нийт 507360 минут шаардагдахаар байна.

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1.600 ажлын цаг буюу (1.600 x 60) 96.000 минут ажиллана.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 10. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
Үндсэн хуулийн цэц	1,077,720	96.000	11
Хүний эрхийн үндэсний комисс	4800	96.000	0.05
Шүүх	502,560	96.000	5

Одоогоор Үндсэн хуулийн цэц 9 цэцийн гишүүн, 3 бүртгэлийн ажилтан, 9 туслах буюу шинжээч, 1 шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, 5 судлаач, 1 хууль зүйн газрын дарга гэсэн, нийт 28 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулдаг. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэрэгжихтэй холбоотойгоор Үндсэн хуулийн цэцэд нийт 11 албан хаагч (гишүүний туслах ороогүй) нэмэгдэхээр байна.

2.3. Гаргах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төсөлд улсаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг эхэлж тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Үндсэн хуулийн цэц маргаан хянан шийдвэрлэхэд бүртгэлийн ажилтан, шүүхийн хуралдааны нарийн бичгийн дарга, шинжээч, судлаач зэрэг бусад албан хаагч оролцдог. Тэдгээр албан хаагчид нь Засгийн газрын 2020 оны 75 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээ”-ээр цалинждаг. Уг цалингийн сүлжээг үндэслэн тэдгээр албан хаагчдын дундаж цалинг 1,500,000 төгрөг гэж үзвэл нэг жилд 18,000,000 төгрөг, түүний НДШ зардалд 2,250,000 төгрөг, нийт 20,250,000 төгрөг зардал гарна гэж тооцооллоо.

Нэгж зардлыг **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт 11. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал
Үндсэн хуулийн цэц	11	20,250,000	222,750,000

2.4. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал болон холбогдох бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

“Материаллаг зардал” гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, нэмэгдсэн ажлын байранд оногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Зардлын төрөл	Зардлын нэр	Зардал /төгрөгөөр/
	Бичиг хэргийн зардал	124,000

Урсгал зардал	Ном, хэвлэл авах	54,745
	Шуудан холбоо	306,812
	Компьютер, тоног төхөөрөмж	2,500,000
	Тавилга, эд хогшил	1,000,000
Зардал	Түлш, халаалт	263,408
	Гэрэл, цахилгаан	128,239
	Цэвэр, бохир ус	599,438
	Урсгал засвар	127,752
	Газрын төлбөр	22,253
Элэгдэл,хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	300,000
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид оногдох		5,526,647
Нийт		110,532,940

НИЙТ ЗАРДЛЫГ ТООЦОХ

Хүснэгт 12. Нийт зардал

Төрөл	Хүний нөөцийн зардал	Материаллаг зардал	Нийт
Нийт зардлын хэмжээ	222,750,000	60,793,117	283,543,117

7.3. Маргаан хянан шийдвэрлэх зардлыг дараах журмаар тодорхойлно:

7.3.1. шинжээч, орчуулагч, хэлмэрч, гэрчид олгох тээвэр, байр, хоолны зардлыг улсын төсвөөс санхүүждэг байгууллагад мөрдөгдөж байгаа албан томилолтын зардлын хэмжээгээр;

7.3.2. шинжээч, орчуулагч, хэлмэрчийн ажлын хөлсийг жишиг үнэлгээг харгалзан тогтоосон хэмжээгээр;

7.3.3. мэдүүлэг өгөхөөр Цэцэд дуудагдсан хугацаанд гэрч цалин, хөдөлмөрийн хөлсөөр хохирсон бол энэ хугацааны цалин, хөдөлмөрийн хөлсний дунджаар;

7.3.4. хөгжлийн бэрхшээлтэй оролцогчийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахад шаардлагатай хэрэгсэл, тоног төхөөрөмж ашигласны төлбөрөөр;

7.3.5. бусад зардлыг зохих журмын дагуу.

Эдгээр зардлыг тооцож үзвэл:

Хүснэгт 13. Гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хамаарах зардал.

Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Зардлын хэмжээ	Зарцуулах хугацаа /мин/	Нийт зардал
Маргаан хянан шийдвэрлэх зардлыг тодорхойлох	шинжээч, орчуулагч, хэлмэрч, гэрчид олгох тээвэр, байр, хоолны зардлыг улсын төсвөөс санхүүждэг байгууллагад мөрдөгдөж байгаа албан томилолтын зардлын хэмжээгээр;	32 ²	33,500 ³	4320 ⁴	12,864,000
	шинжээч, орчуулагч, хэлмэрчийн ажлын хөлсийг жишиг үнэлгээг харгалзан тогтоосон хэмжээгээр;	32	50000 ⁵	480	4,800,000
	мэдүүлэг өгөхөөр Цэцэд дуудагдсан хугацаанд гэрч цалин, хөдөлмөрийн хөлсөөр хохирсон бол энэ хугацааны цалин, хөдөлмөрийн хөлсний дунджаар;	32	75000	480	2,400,000
	хөгжлийн бэрхшээлтэй оролцогчийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахад шаардлагатай хэрэгсэл, тоног төхөөрөмж ашигласны төлбөрөөр;	14 ⁶	40000	480	560,000
Нийт		110	198,500	5760	20,624,000

² Нийт хэрэг үүсгэсэн өргөдөл, хүсэлт, мэдээллийн 20%-аар тооцов.

³ Сангийн сайдын Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2011 оны 132 дугаар тушаалд зааснаар улс төрийн боло төрийн захиргааны албан хаагчийн албан томилолтын зардалтай жишин тооцов.

⁴ Улаанбаатар хотоос хамгийн хол аймгуудаас ирэх хугацаагаар тооцов.

⁵ Монголын мэргэшсэн орчуулагчдын хөгжлийн холбооны аман орчуулгын жишиг үнэ, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан шинжээчийн жишиг үнэлгээг харгалзан тооцов. [Шүүхийн Ерөнхий Зөвлөл \(judcouncil.mn\)](http://judcouncil.mn).

⁶ Статистик мэдээллээс харахад 2022 оны байдлаар МУ-д нийт 115,115 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа бөгөөд үүнийг нийт ирүүлэх өргөдөл, хүсэлт, мэдээллийн тоотой харьцуулж тооцоолов.

2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

- 1.Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;
- 2.Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;
- 3.Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;
- 4.Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;
- 5.Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх;

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/ хуульд тусгагдсан чиг үүргүүд нь жилийн туршид тасралтгүй үргэлжлэх шинжтэй байсан тул тохиолдлын тоог 1 гэж авч үзсэн тул тохиолдлын тоог дахин багасгах боломжгүй. Түүнчлэн Зөвлөгөөний хуралдааны тов, зохих шийдвэр, хуульд заасан дүрэм, журам, дэгийг олон нийтэд мэдээлэх, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, гишүүний тусгай санал, мэдээллийг нийтэд ил тод нийтлэх, мэдээллийн санг үүсгэх нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх онцгой ач холбогдолтой байх тул олон нийтэд мэдээлэх мэдээллийн агуулгыг багасгах, давтамжийг бууруулах нь оновчтой шийдэл биш байна.

Харин маргаан хянан шийдвэрлэхэд шаардлагатай судалгаа, мэдээллийн санг бүрдүүлэх, тогтмол шинэчлэх чиг үүргийг цахим болон цаасан хэлбэрээр гүйцэтгэх талаар хуулийн төсөлд дурдсан тул тус санг оновчтой зохион байгуулж, хөгжүүлэх ажлыг анхааралтай авах нь зүйтэй.

IV ДҮГНЭЛТ, САНАЛ

Хуулийн төсөлд зардлын тооцоо хийх нь хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад хэдий хэмжээний зардал, ачаалал үүсгэхийг урьдчилан гаргах зорилготой. Үүний хүрээнд, Үндсэн хуулийн цэцийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл батлагдсанаар үүсэх зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ыг баримтлан тооцов.

Нэг. Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд дурдагдсан нэмэлт чиг үүргийг хэрэгжүүлэхэд 11 албан хаагч нэмэлтээр шаардлагатай бөгөөд тэдгээрийн хүний нөөцийн болон бусад материаллаг зардалд жил ойролцоогоор **304,167,117** төгрөг шаардлагатай.

Хоёр. Зардал-үр өгөөжийн үнэлгээ

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл батлагдсанаар дагалдан гарах зардал хэдийгээр нэмэгдэх хандлагатай боловч хуулийн төслийн үр өгөөжтэй харьцуулахад үр өгөөж нь илүү учир зардлыг байж болохуйц хэмжээ гэж дүгнэв.